



**MONGOLICA  
PRAGENSIA '02 / '03  
ЦУВРАЛ**



Дэлхий дахинаа Монголын судлалын чиглэлээр бие даан гарч буй цуврал бичигийн өвөрмиц нэг нь *Mongolica Pragensia* даруй мөн. Өвөрмиц гэдэгийн учир нь гэвэл, францад гардаг *Etudes mongoles ... et siberiennes* хэмээх жил тутамын цуврал гол төлөв угсаатны зүйд түлхүү анхаардаг, АНУ, БНХАУ, Солонгос болон Японд гардаг *Mongolian Studies, Bulletin of Japanese Association for Mongolian Studies* сэтгүүлүүд монголын судлалын ерөнхий асуудалыг хамардаг гэвэл Чехийн энэхүү цуврал нь **орчин цагийн монгол хэлний аман хэрэглээний онцлогийг** тал талаас нь судлах гол зорилготой бөлгөө. Судлагааны энэхүү чиглэл нь бусад улс оронд, тэр ч бүү хэл Монгол Улсад ч төдийлөн дэлгэр хөндөөд байдаггүй, монголын судлалд анх хөл тавих хэнд ч болов тойрохгүй, дайрч гарах шаардалга бүхий өвөрмиц чиглэлийг буй болгож чадсан цуврал гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монгол хэлний судлагааны энэхүү өвөрмиц чиглэл нь дэлхийн хэлшинжлэлийн ухаанд Прагийн дэгийг буй болгосон Чех түмэний эрдэм шинжилгээний уламжлалыг арга буюу давхар санагдуулж байна.


Энэхүү *Mongolica Pragensia* цуврал хэдийгээр бие даан тулгар гарч байгаа боловч судлагааны уг чиглэл 1970-аад оноос Чехийн Карлын Их сургуулийн Монгол хэлний салбарт буй болж 1979 онд Праг хотноо хэвлэгдсэн *Орчин цагийн Монгол хэлний сурах бичиг*-т хэдийнээ биелэлээ олсон бөгөөд хэдийгээр тэрхүү сурах бичиг Карлын Их сургуульд хамаарах авч МУИС болон Солонгосын Данкуук Их сургуульд 1990-ээд оны эхээр Монгол хэлний салбар байгуулагдахад уг сурах бичгийг гарын авалга болгон хэрэглэж байсаныг миний бие сайн

мэдэх билээ. Энэ бол уг номын практик ач холбогдолыг харуулж байгаа хэрэг (Энэ ташрамд хэлэхэд, уг сурах бичигийн нэмэж зассан хоёрдугаар хэвлэл одоо Праг хотноо гарч байна).

Орчин цагийн монгол ярианы хэлний судлагааг авч үзвэл харьцангуй хязгаарлагдмал, авиазүйн төвшинд лабораторийн аргаар судласан зүйл байх боловч тэр нь их төлөв хэлний тогтонги байдалыг тодорхойлсон ажээ. Харин хэлний хэрэглээний үүднээс, өгүүлэхүйн явцад илрэн гардаг авиазүйн элдэв өөрчлөлт, хувирал, хэл найруулгын өнгө аясын онцлогийг авч үзсэн судлагаа энэ хэр үгүйлэгдсээр байсан билээ. Ийнхүү үгүйлэгдэж буй салбарт Чехийн монгол хэл судлалчид үнэтэй хувь нэмэрээ оруулж байгааг хэлэхэд таатай байна.

Чехийн Карлын Их Сургуулийн Монгол хэлний салбарт хэрэглээний монгол хэлийг угсаа хэлшинжлэл, нийгэм хэлшинжлэлийн үүднээс нэгэн цогц болгон авч үзэх шинэ чиглэлийг буй болоход уг чиглэлийг үүдхэж буй болгосон профессор Ярослав Вацек (Jaroslav Vacek)-ийн эрдэм шинжилгээний ажилын туршилга мэдэлгэ, монгол хэлний салбарын эрхилэгч доктор Алена Оберфальзерова (Alena Oberfalzerova) зэрэг чех багш нар болон урилгаар ажилласан болоод ажиллаж байгаа монгол багш нар, ялангуяа профессор Чой. Лувсанжав, Ж. Лувсандорж нарын хүчин зүтгэлийг дурдалгүй өнгөрөх аргагүй.

Энэхүү цувралын дараагийн *Mongolica Pragensia* '04 дугаар одоо хэвлэгдэн гарах гэж байгаа бөгөөд цааш цаашид үргэлжлэн гарч дэлхийн монгол судлалын хөгжилд хувь нэмэрээ оруулсаар байх болно гэж гүнээ итгэж байна.



Карлын Их сургуульд монгол хэлний хүрээнд гүйцэтхэж буй эрдэм шинжилгээний ажилын гол чиглэл нь орчин цагийн монгол ярианы хэлний судлагаа мөн боловч тонгол хэлний түүхэн судлал, тухайлбал монгол хэлийг Алтай овогийн бусад хэл болон Дравид хэлтэй харьцуулан судлах ажилыг Я. Вацек профессор олон жилийн туршид хийж ирсэн бөгөөд судлагааны нэгэн шатны тайлан болсон *Dravidian and Altaic 'Water-Viscosity-Gold'* гэдэг бүтээл нь 2002 онд нийтлэгдэн гарчээ.

Энэ ном нь зөвхөн монгол хэл төдийгүй Алтай овог хэл болон Дравид хэлний хөгжилийн үлэмжхэн эртний түүхийг мөшгин сэргээх эрдэм шинжилгээний их үйлсэд үнэт хувь нэмэр болоод зогсохгүй харьцуулсан хэлшинжлэлийн салбарт дээрхи хэлнүүдийн хэрэглэгдэхүүнийг хэвшинжийн үүднээс загварчилан судлах шинэ аргачлалыг дэвшүүлж гаргасанаараа судлагааны үлэмжхэн ач холбогдолтой гэдэгийг онцлон дурдууштай байна.

Ц. Шагдарсүрэн